

БАНК БУС САНХҮҮГИЙН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, гадаад валютын арилжааны мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, гадаад валютын арилжаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаад хяналт тавьж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2 Санхүүгийн зохицуулах хороо нь Валютын зохицуулалтын тухай хууль болон энэ журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Гадаад валютын арилжаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-ын ажлын байранд дараах шаардлагыг тавина:

2.1.1. ажлын байрны аюулгүй байдлыг хангасан байх

2.1.2. санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор дүрс бичлэгийн техник хэрэгсэлтэй байх ба дүрс бичлэгийг нэг сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын системтэй байх;

2.1.3. валют шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.1.5. валютыг худалдан авах, худалдах ханшийг электрон самбар болон цахим талбараар нийтэд ил тод мэдээлдэг байх;

2.1.6. татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд холбогдох баталгаажсан тоног төхөөрөмж бүхий системтэй байх;

2.1.7. валютыг худалдах, худалдан авах тухай бүр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хувь хүн, хуулийн этгээдэд төлбөрийн баримтыг цахимаар болон цаасаар хэвлэж олгох төхөөрөмжтэй байх;

2.1.8. Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдсон байх.

2.2. Цахим систем ашиглаж гадаад валютын арилжаа эрхлэх тохиолдолд 2.1.1-2.1.3-т заасан шаардлага хамаарахгүй болно.

2.3. Гадаад валютын арилжаа эрхлэх ББСБ-ын үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.3.1. удирдлага, ажилтан нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны сургалтуудад хамрагдсан байх ба ажилтан нь хуурамч мөнгөн тэмдэгтийг таньж мэдэх чадвартай байх;

2.3.2. харилцагчийг таньж мэдэх зорилгоор Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд нэвтэрч хурууны хээ болон хуулийн этгээдийн регистрийн дугаараар баталгаажуулах;

2.3.3. харилцагч нь гадаадын иргэн, хуулийн этгээд бол иргэний паспорт, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг хуулбарлан авч баталгаажуулах;

2.3.4. гадаад валютын арилжаа хийх тухай бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 1.1.14-д заасан төлбөрийн баримтыг зориулалтын төхөөрөмжөөс хэвлэж цаасаар болон цахимаар харилцагчид олгодог байх;

2.3.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах;

2.3.6. ажилтан нь мөнгөн тэмдэгтийг тухай бүр хянах бөгөөд гүйлгээнээс хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх.

2.4. Гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх ББСБ-ын салбар нэгж нь энэхүү журмын 2.1, 2.3-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

2.3. Гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх ББСБ нь хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцагчийн мэдээллийг бусдад өгөх эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглоно.

2.6. Гадаад валютын арилжааг пос төхөөрөмж, бэлэн бус гүйлгээгээр хийх тохиолдолд ББСБ-ын харилцах данснаас бусад дансыг ашиглахыг хориглоно.

ГУРАВ. ХАРИУЦЛАГА

3.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.